


ХИМИЙН ХОРДЛОГЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН 7 ХОНОГИЙН МЭДЭЭ


НЭГ. Угаарын хийн цочмог хордлогын мэдээ

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хор судлал, шуурхай удирдлагын албанд 2024 оны 12 дугаар сарын 29-ний өдрөөс 2025 оны өдрөөс 11 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар буюу **эпидемиологийн 1-44 дүгээр долоо хоногт** нийт Нийслэлийн 7 дүүрэг, 11 аймагт **1844** хүн угаарын хийн хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан.



Угаарын хийн хордлогод өртсөн иргэдийг байршлаар авч үзвэл:

Угаарын хийн хордлогод өртсөн 1844 тохиолдлын 95% /1756/ нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн бол, 6% /88/ нь орон нутагт (Баян-Өлгий /30/, Дорнод /3/, Орхон /11/, Өмнөговь /9/, Сэлэнгэ /6/, Төв/16/, Дорноговь /4/, Дархан /4/, Говь-Алтай /3/, Баянхонгор /1/, Дундговь /1/) бүртгэгдсэн байна.




Нийслэлд угаарын хийн хордлогод өртсөн тохиолдлыг дүүрэг тус бүрээр авч үзвэл хамгийн өндөр буюу **552** тохиолдол Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн байна.

ЭПИДЕМИОЛОГИЙН **44** ДҮГЭЭР ДОЛОО ХОНОГТ

(2025.10.26 – 11.1)

2025 оны эпидемиологийн 44 дүгээр долоо хоногт 57 угаарын хийн хордлого бүртгэгдсэн байна. Өмнөх оны мөн үеэс 13.6 хувиар буурсан, 5 жилийн дунджаас 5.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.




ХОЁР. Бусад химийн бодисын цочмог хордлогын мэдээ

Цэргийн төв эмнэлгийн харьяа Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд **эпидемиологийн 1-44 дүгээр долоо хоногт** нийт **1181** иргэн химийн цочмог хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна.


689Эмнэлгийн
тусламж авч буцсан**492**Хэвтэн эмчлүүлж
эдгэрч гарсан**0**

Нас барсан

Эрэгтэй
47%Эмэгтэй
53%

Химийн хордлогыг насны бүлгээр авч үзвэл 0-9 буюу бага насны хүүхдүүд хамгийн их хордлогод өртөж байна.

2025 оны **эпидемиологийн 44 дүгээр долоо хоногт** химийн цочмог хордлогод өртсөн **32** хүн хандаж эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна. Энэ үзүүлэлт нь өмнөх оны мөн үеээс 13.5 хувиар буурсан бол сүүлийн 5 жилийн дунджаас 131.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.



Хүснэгт 1. Химийн цочмог хордлого, шалтгаанаар (Эпи – 44 долоо хоногт)

№	Шалтгаан (Сэдэл)	Санаатай	Санамсаргүй	Нийт
1	Химийн бодисын хордлого	0	13	13
2	Эмийн хордлого	8	11	19
Нийт		8	24	32

Нийт 32 хордлогын тохиолдол бүртгэгдсэнээс 19 (59.4%) нь эмийн хордлого, 13 (40.6%) нь химийн бодисын хордлого байна. Санамсаргүй хордлого 24 (75%) тохиолдол, санаатай хордлого 8 (25%) тохиолдол тус, тус бүртгэгдсэн байна. Энэ нь эм болон химийн бодисыг буруу хэрэглэх, хадгалах дадал сул байгааг илтгэн, урьдчилан сэргийлэх сургалт, мэдээллийг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.

-oOo-